

СЭНДЛИ ББСБ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023.04.07

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Blue sky Tower-ын 2 давхарт, Emerald танхимд 14-н цагаас эхлэв. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн батална. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах тухай

Б.Наранбат: /10 минут/ Сайн байцгаана уу? “Сэндли ББСБ” Нээлттэй хувьцаат компанийн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Сэндли ББСБ нь олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгон арилжаалж нээлттэй хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилж бүртгэлийн өдрийн байдлаар 3608 хувьцаа эзэмшигчтэй болсон байна.

Компанийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9 дүгээр сарын 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр 04 дугаартай тогтоолоор шийдвэрлэсэн. Энэ удаагийн хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна. Ингээд Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал нээснийг мэдэгдэе. Та бүхэнд хурлыг дэгийг танилцуулахаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг-ийг урьж байна.

Б.Мөнхцэцэг: Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцуулая. /хурлын дэгийг танилцуулав./

Б.Наранбат: Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн ирцийн мэдээлэл гарсан байна. Тооллогын комиссын дарга Д.Баярбат танилцуулна.

Д.Баярбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Сэндли ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн мэдээллийг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулая.

“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

*Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хүчин төгөлдөр болсныг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй нийт 223,570,000 ширхэг хувьцаатайгаас 156,632,590 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор нийт саналын эрхтэй хувьцааны 70,06 % болж Хувьцаа эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

Д.БАЯРБАТ

Б.Наранбат: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Сэндли ББСБ” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулна. /компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулав/

Б.Наранбат: Та бүхэн компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцлаа. Бид анх IPO хийхдээ ногдол ашгийн бодлогоо цэвэр ашгийн 20%-ийг тараахаар тусгасан. Энэхүү бодлогынхоо хүрээнд 2022 оны цэвэр ашгийн 20,064%-ийг буюу 614,817,500 төгрөгийг тараахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн. /Ногдол ашигтай холбоотой ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулав/

Ингээд та бүхэнд компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцууллаа. Өнөөдрийн ТУЗ-ийн хурлаар нийт 2 асуудалд санал хураалтаар шийдвэрлэнэ. Санал хураалт явагдах асуудлыг танилцуулахаас өмнө та бүхэнд саналаа хэрхэн өгөх талаар зааврыг танилцуулая. Тооллогын комиссын дарга Д.Баярбат захирлыг урьж байна.

Д.Баярбат: Санал өгөх заавар танилцуулав.

Б.Наранбат: Та бүхэн саналаа хэрхэн өгөх талаар ойлголттой болсон гэж бодож байна. Ингээд шийдвэрлэх 2 асуудлыг танилцуулая. Танилцуулж байх хугацаанд та бүхэн саналаа өгөх бүрэн боломжтой.

Нэгдүгээр асуудлын хувьд, та бүхэнд танилцуулсан компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөл хуралдан дүгнэлт гаргасан бөгөөд энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах хуулийн шаардлага байдаг. Ингээд та бүхэнд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг уншиж танилцуулая.

Хоёрдугаар асуудлын хувьд, ТУЗ-ийн 2023 оны жилийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлана. Үүнд ТУЗ-ийн хурлын зардал, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалингийн зардал багтаж байгаа болно.

Б.Наранбат: Санал хураалтын дүнтэй танилцлаа. Энэхүү хурлаар үндсэн хоёр асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд гарах шийдвэрийн төслийг танилцуулья. /шийдвэрийг уншиж танилцуулав/

“Сэндли ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар үндсэн хоёр асуудлыг хэлэлцэн баталлаа. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа идэвх санаачлагатай оролцож, өөрсдийн үнэт саналаа өгсөн та бүхэндээ баярлалаа.

Компанийн цаашдын үйл ажиллагаанд та бүгдийн оролцоо юу юунаас илүү чухал гэдгийг энэ дашрамд хэлмээр байна.

Ингээд “Сэндли ББСБ” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал өндөрлөснийг мэдэгдье.

Шийдвэрлэсэн асуудал:

3. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланд гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
4. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах тухай

Хурлын дарга Б.Наранбат

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг



Та бүхэнд санал хураалт явагдах 2 асуудлыг танилцууллаа. Санал хураалт явагдаж дуусах хүртэл хугацаанд үргэлжлэх тул та бүхэн саналаа өгөөрэй. Санал хураалтын дүн гарах хүртэл та бүхэн ард байгаа цай, кофе уух боломжтой. Санал өгөх талаар туслалцаа авах тохиолдолд манай компанийн ажилчид та бүхэнд туслах болно.

Хувьцаа эзэмшигчдээс асуулт асуув.

Хувьцаа эзэмшигч: Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлантай танилцлаа. Бонд гаргасан гэж байна. Тэр нь яг юу вэ? Яаж авах боломжтой байдаг вэ? Хоёрдугаарт, Хадгаламж байдаг уу? Мөнгөө хадгалуулах боломжтой юу?

Б.Наранбат: Бонд гэдэг нь та хугацаа болон хүү тохироод компанид хөрөнгө оруулж буй хэлбэр юм. Банкинд бага хүүтэй хадгалуулж байснаас өөрийн хувьцаа эзэмшиж буй компанид илүү өндөр хүүтэйгээр хадгалуулах буюу хөрөнгө оруулах бүрэн боломжтой. Манай компанийн хувьд оны өмнө нээлттэй бондын материалыг бүрдүүлэн зохицуулагч байгууллагуудаас зөвшөөрөл авч 8,5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Бидний цаашдын төлөвлөгөө бол ХӨБҮЦ болон итгэлцэл татахаар бэлтгэж ажлуудыг хийж байгаа. Иймд та өөрийн хувьцаа эзэмшдэг байгууллагаас хадгаламжийн хүүгийн өгөөжөөс хэд дахин илүү өгөөжтэй үнэт цаасыг худалдан авах бүрэн боломжтой юм.

Хувьцаа эзэмшигч 2: Танилцуулгаас мөнгө байсаар байтал зээл гаргалтыг зогсоож, санхүүгийн төлөвлөгөөнд байсан ашигт хүрч чадаагүй гэж ойлголоо. Яагаад зээлээ гаргаагүй вэ? Зах зээл муу байсан уу? Зээлийн эрэлт муу байна уу?

Б.Наранбат: Бид санхүүгийн төлөвлөгөөг өнгөрсөн оны 5 дугаар СЗХ-нд материалаа өгөхдөө баталсан. Гэвч IPO бидний төлөвлөснөөс 2 сар гаруй хоошилж татан төвлөрүүлсэн мөнгөн дүн бидэнд орж ирэх гэж хугацаа их алдсан учир зорилтот саруудад зээл гаргаж чадаагүй. Харин IPO-өөр татан төвлөрүүлсэн мөнгөн дүн орж ирснээр зээлийн багцийг нэмэгдүүлсэн. Гэвч Монгол улсын эдийн засаг болон улс төрийн байдал буюу өнгөрсөн оны 12 дугаар сард жагсаал, цуглаан ихээхэн зохион байгуулагдсантай холбоотойгоор хэрэглэгчдийн зээл төлөлтийн эрсдэлийг тооцон зээл гаргалтыг хязгаарласан. Өөрөөр хэлбэл, учирч болох эрсдэлд тулгуурлан зээл гаргалтыг хязгаарласан явдал болсон.

Хувьцаа эзэмшигч 3: Хувьцаа эзэмшигчдэд зориулсан тусгай хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл гэж байдаг уу? Бид тэтгэврийн зээл бага хүүтэй учраас авчихдаг. Танайд тэтгэврийн хүүний нөхцөлөөс тэнцүү буюу бага хүүтэй байвал бид бүхэн компанийхаа үйл ажиллагааг дэмжин зээл авах болно шүү дээ.

Б.Наранбат: Хувьцаа эзэмшигчдэд тусгайлан зориулсан зээл байхгүй байна. Харин компани шинээр олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд Хувьцаа эзэмшигч та бүхэнд хамгийн эхэнд санал болгох байдлаар давуу талуудыг олгох боломжтой. За ингээд өөр асуулт байхгүй бол санал хураалтыг үргэлжлүүлэе.

Д.Баярбат: Санал хураалтын шугам хаагдсан байна. Үүгээр санал хураалт явагдаж дууссан тул санал хураалтын дүнг уншиж танилцуулая. /Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав/